



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Дашинчилэн сумын Засаг даргын Тамгын газрын
2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2023/87/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.open.audit.mn</p> <p>Булган аймаг 2024 он</p>	<p>Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас: 7034-2580 Цахим хаяг: Erdeneb@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 7034-2716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Д.Анхбаяр Утас: 7034-2495 Цахим хаяг: Ankhubayard@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхлагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.02.23 № 213

танай _____ ны № _____ т

ДАШИНЧИЛЭН СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Ц.БОЛОРЦЭЦЭГ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дашичилэн сумын засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсаныг хангалттай, зохистой аудитын нотолгоонд үндэслэн нотолсны улмаас 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн шууд захирагчийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар 15,200.3 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.7, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 1.2.1, 1.2.2, 2.7, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 7.1 дэх заалт, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Үүнд:

- Засаг даргын нөөц сангаас Хишиг-Өндөр, Бүрэгхангай сумдын 100 жилийн ойд зориулж хандив, дэмжлэг 2,000.0 мянган төгрөгийг хууль, тогтоомж зөрчиж өгсөн.
- Албан томилолтоор ажиллаж байгаа аймгийн Засаг даргаар ахлуулсан хэлтэс, агентлаг, сумдын Засаг дарга нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэгт байр хоол, хүнсний зардлыг давхардуулан, үр ашиггүй, зориулалт бусаар 1,970.7 мянган төгрөг зарцуулсан байна.

006020493

- Цэрэг эх оронч үзэл олгох бүхий "Бидний бахарал" сэдэвт арга хэмжээний анхан шатны баримт дутуу, албан томилолтоор ажиллаж байгаа хүмүүст хоол хүнс, буудал байрны зардал давхардуулан, үр ашиггүй, зориулалт бус зардал 2,718.5 мянган төгрөг зарцуулсан байна.
- Аймгийн засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 08-ний өдрийн А/473 дугаар захирамжаар сахилгын шийтгэл ногдуулсан сумын Засаг даргад хууль, тогтоомж зөрчиж Тамгын дарга тушаал гаргаж урамшуулал 1,267.5 мянган төгрөг олгосон байна.
- Албан томилолтыг олгохдоо тушаал шийдвэргүйгээр 7,243.5 мянган төгрөг олгосон байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Сумын Засаг даргын тамгын газар үйл ажиллагаандаа Олон улсын Чанарын менежментийн тогтолцоо-Шаардлага ISO 9001:2015 (MNS ISO 9001:2016) стандартыг нэвтрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Иргэдийн амьдрах орчныг сайжруулж, хотын түгжрэлийг бууруулах зорилгоор жилийн дундуур төсвийг тодотгож, төрийн албан хаагчдын цалин хөлсний хэмжээг нэмэгдүүлснээр нийт төсвийг 639,621.3 мянган төгрөгөөр баталсан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

(мянган төгрөгөөр)

	Үзүүлэлт	2022.12.31.	2023.12.31.
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	187,189.4	167,984.8
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,053,463.6	1,201,843.7
	Нийт хөрөнгийн дүн	1,240,653.0	1,369,828.6
	Нийт өр төлбөрийн дүн	-	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,240,653.0	1,369,828.6
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,240,653.0	1,369,828.6
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	655,582.3	915,759.1
	Үйл ажиллагааны зардлын дүн	566,513.0	786,251.3
	Үйл ажиллагааны үр дүн	89,069.3	129,507.8
	Үйл ажиллагааны бус үр дүн	(68,843.9)	(332.2)
	Үйл ажиллагааны нийт үр дүн	20,225.4	129,175.6
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,220,427.5	1,240,653.0
	Тайлант оны үр дүн	20,225.4	129,175.6
	Эцсийн үлдэгдэл	1,240,653.0	1,369,828.6
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	445,258.4	647,091.5
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	419,787.7	623,907.3
	Үйл ажиллагааны ЦМГ	25,470.7	23,184.2
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(25,470.7)	(23,184.2)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	-	608,475.9
	Урсгал зардал	-	608,475.9
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	-	608,475.9
	Улсын төсвөөс санхүүжих	-	602,255.9
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	3,220.0

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 1,532,516.6 мянган төгрөгийн 6 алдаа¹ илэрснээс аудитын явцад 1,532,516.6 мянган төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

- Төсвийн шууд захирагчийн 2024 оны 01 дүгээр сарын 24-ны 01/29 тоот албан бичгээр ирүүлсэн санхүүгийн тайлан нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасан бүрэлдэхүүн, иж бүрдлийг хангаж ирүүлээгүй,
- Бараа материалын тайлангийн аж ахуйн материал, сэлбэг хэрэгсэл, түлш шатах тослох материал, мал амьтадын дансанд үнэ төлбөргүй орлогыг илүү авч тайлагнасан,
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд батлагдсан төлөвлөгөөг багаж, техник хэрэгсэл, хог хаягдлын зардал, БҮТЭЗ-ийн зардал, авто тээврийн оношилгоо, бараа үйлчилгээний бусад зардал, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг зөрүүтэй тайлагнасан,
- Үндсэн болон нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайланд төвлөрүүлэх шилжүүлгийг тохируулах бичилт хийж тайлагнаагүй, үндсэн үйл ажиллагааны зардлаар тайлагнасан,
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд хөрөнгө бэлтгэсэн зардлыг тохируулах бичилт хийгээгүй, хөрөнгийн зардлаар тайлагнасан нийт 1,532,516.6 мянган төгрөгийг алдааг УСНББОУС 1- Санхүүгийн тайлангийн толилуулга, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийг хөтлөх заавар”-ын дагуу залрууллаа.

Аудитаар нийт 15,200.3 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 3,267.5 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 4,689.3 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 7,245.3 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгч ажиллалаа.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 2 төлбөрийн акт, 2 албан шаардлага, 1 зөвлөмжийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 6,702.6 мянган төгрөгөөр их тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Засаг даргын нөөц сангаас Хишиг-Өндөр, Бүрэгхангай сумдын 100 жилийн ойд зориулж 2,000.0 мянган төгрөгийн хандив, дэмжлэг өгч, төсвийг үр ашиггүй, зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн өмч, хөрөнгийг үндэслэлгүйгээр бусдад хандивласан, үнэ төлбөргүй шилжүүлсэн 2,000.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

2. Сахилгын шийтгэлтэй сумын Засаг даргад хууль, тогтоомж зөрчиж, томилсон эрх бүхий албан тушаалтны шийдвэргүй, Засаг даргын Тамгын даргын

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2023 оны Б/41 тоот тушаалаар оны эцэст 1,267.5 мянган төгрөгийн урамшуулал олгосон.

Шийдвэрлэсэн нь: Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон 1,267.5 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

5.2 Албан шаардлага

1. Албан томилолтоор ажиллаж байгаа аймгийн Засаг даргаар ахлуулсан хэлтэс, агентлаг, сумдын Засаг дарга нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэгт байр хоол, хүнсний зардлыг давхардуулан, үр ашиггүй, зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалын хавсралтаар баталсан журмын 7.1 дэх заалт эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зориулалт бусаар зарцуулсан 1,970.8 мянган төгрөгийг дахин гаргахгүй байх таслан зогсоох албан шаардлага өглөө.

2. Цэрэг эх оронч үзэл олгох бүхий "Бидний бахархал" сэдэвт арга хэмжээний анхан шатны баримт дутуу, албан томилолтоор ажиллаж байгаа хүмүүст хоол хүнс, буудал байрны зардал давхардуулан, үр ашиггүй, зориулалт бус зардал гаргасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалын хавсралтаар баталсан журмын 7.1 дэх заалт эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зориулалт бусаар зарцуулсан 2,718.5 мянган төгрөгийг дахин гаргахгүй байх таслан зогсоох албан шаардлага өглөө.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тушаал шийдвэргүйгээр 7,243.5 мянган төгрөгийн албан томилолтыг зарцуулсан нь Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчдад нөхөх төлбөр олгох тухай" журам, НББ-ын тухай хуулийн 4 дүгээр зүйл, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Албан томилолтоор ажиллах тухай бүрд шийдвэр гаргаж, НББ-ийн тухай хуулийн дагуу анхан шатны баримтаар ажил гүйлгээг хийж хэвших.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 06 дугаар сарын 10-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:
Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

Алдааны товч утга	(мянган төгрөгөөр)											
	Нийт алдаа		НББ-ын бодлогыг буруу хэрэгжүүлсэнтэй холбоотой		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн шууд захирагчийн 2024 оны 01 дүгээр сарын 24-ны 01/29 тоот албан бичгээр ирүүлсэн санхүүгийн тайлан нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасан бүрэлдэхүүн, иж бүрдлийг хангаж ирүүлээгүй	1	1,383,899.40	1	1,383,899.40			1	1,383,899.40				
Бараа материалын тайлангийн аж ахуйн материал, сэлбэг хэрэгсэл, түлш шатах тослох материал, мал амьтадын дансанд үнэ төлбөргүй орлогыг илүү авч тайлагнасан	1	87,160.00	1	87,160.00			1	87,160.00				
Төсвийн гүйцэтгэлийн тайланд батлагдсан төлөвлөгөөг багаж, техник хэрэгсэл, хог хаягдлын зардал, БҮТЭЗ-ийн зардал, авто тээврийн оношилгоо, бараа үйлчилгээний бусад зардал, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг зөрүүтэй тайлагнасан	1	31,206.90	1	31,206.90			1	31,206.90				
Үндсэн болон нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайланд төвлөрүүлэх шилжүүлгийг тохируулах бичилт хийж тайлагнаагүй, үндсэн үйл ажиллагааны зардлаар тайлагнасан	1	7,066.10	1	7,066.10			1	7,066.10				
Төсвийн гүйцэтгэлийн тайланд хөрөнгө бэлтгэсэн зардлыг тохируулах бичилт хийгээгүй, хөрөнгийн зардлаар тайлагнасан	1	23,184.20	1	23,184.20			1	23,184.20				

Дүн

3

1,532,516.60

3

1,532,516.60

3

1,532,516.60

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал				
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	А.Т тоо	Тоо	Дүн			
Засаг даргын нөөц сангаас Хишиг-Өндөр, Бүрэгхангай сумдын 100 жилийн ойд зориулж хандив, дэмжлэг өгсөн.	1	2,000.0	1	2,000.0									
Аймгийн засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 08-ний өдрийн А/473 дугаар захирамжаар сахилгын шийтгэл ногдуулсан сумын Засаг даргад хууль, тогтоомж зөрчиж Тамгын дарга тушаал гаргаж урамшуулал олгосон.	1	1,267.5	1	1,267.5									
Албан томилолтоор ажиллаж байгаа аймгийн Засаг даргаар ахлуулсан хэлтэс, агентлаг, сумдын Засаг дарга нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэгт байр хоол, хүнсний зэрдлыг давхардуулан, үр ашиггүй, зориулалт бусаар зарцуулсан.	1	1,970.7			1	1,970.7							
Цэрэг эх оронч үзэл олгох бүхий "Бидний Бахархал" сэдэвт арга хэмжээний анхан шатны баримт дутуу, албан томилолтоор ажиллаж байгаа хүмүүст хоол хүнс, буудал байрны зардал	1	2,718.5			1	2,718.5							

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Санал дүгнэлт гаргасан	Түгвэрт хамруулсан	Аудит хийсэн хэлбэр	Зөрчлгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	Дашинчилэн сумын ЗДТГ	1	1				1		
	ТШЗ-ийн дүн	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1				1		